

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГАТАЙ 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 02 дүгээр сарын 17-ны өдөр

Мандалговь хот

Нэг.Гэрээний агуулга, зорилго

- 1.1 Дундговь аймгийн Засаг дарга, Соёл, урлагийн газрын дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний зорилго нь шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, нутгийн захиргааны төрийн бүхий л байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, Монгол улсын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах чиглэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оршино.
- 1.2 Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас **Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат**, нөгөө талаас **Дундговь аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цогзолмаа** нар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж, 2 хувь үйлдэв.
- 1.3 Уг гэрээ болон гэрээний хавсралтаар Дундговь аймгийн Засаг дарга болон **Дундговь аймгийн Соёл, урлагийн газрын даргын** харилцан хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ, түүний тоо хэмжээ, чанарт тавих шаардлага, гэрээний биелэлтийг дүгнэх бусад нөхцөлийг тусгав.
- 1.4 Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжуудтай нийцүүлэн зохицуулна.
- 1.5 Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг /хавсралт/ байна.

**Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг**

- 2.1 Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлнэ.
- 2.2 Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж төрөөс иргэдэд үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, төсвийн үйл ажиллагааг ил тод болгоно.
- 2.3 Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэл, аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.
- 2.4 Төрийн бүх байгууллагад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага зохицуулалтаар хангана.
- 2.5 Нутгийн захиргааны байгууллагуудад чанарын менежментийн олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.6 Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.7 Агентлагийн дарга нарыг албан болон хувийн ажлаар гадаадад явах, удирдамж, хөтөлбөр, хүсэлттэй танилцаж, зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

- 2.8 Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлэх, төрийн албанд сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

### **Гурав. Соёл, урлагийн газрын даргын хүлээх үүрэг**

- 3.1 Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, УИХ, Засгийн газар, УОК-оос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэх ажлыг аймгийн Засаг даргын өмнө хариуцна.
- 3.2 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.
- 3.3 Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, салбарын болон аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилт, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж ажиллана.
- 3.4 Аймгийн Засаг даргын Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Соёлын сайдтай байгуулсан гэрээг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хамтарч ажиллана.
- 3.5 Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шударга, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй удирдан чиглүүлж, ажлын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгаж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.
- 3.6 Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албан Мерит тогтолцоог хэрэгжүүлж ажиллана.
- 3.7 Хуулиар олгосон чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог, стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нийцүүлэн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шатлан дэвшүүлэх судалгаанд үндэслэн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.
- 3.8 Шилэн данс, цахим мэдээллийн ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чанд баримтлан, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллана.
- 3.9 Гадаадын зээл тусламж, ОУБ-ын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх эдийн засаг нийгмийн үр ашигтай ажлыг хугацаанд нь зохион байгуулна.
- 3.10 Аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авна.
- 3.11 Төрийн албан хаагчидтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг харгалзан дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчидтай хариуцлага тооцож ажиллана.
- 3.12 Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэн улирлаар тайлагнаж ажиллана.
- 3.13 Албаны болон хувийн ажлаар гадаадад явахдаа аймгийн ЗДТГ-ын харьяа хэлэст мэдэгдэж, удирдамж хөтөлбөрөө батлуулан аймгийн Засаг даргаас зөвшөөрөл авч явна.
- 3.14 Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай, чанартай зохион байгуулж ажиллана.
- 3.15 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллана.
- 3.16 Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх, e-mongolia системийг иргэдэд сурталчлах зэрэг төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллана.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 01 дүгээр сарын 02

Мандалговь хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /Сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2022 он/	Зорилтот түвшин /2023 он/		Хугацаа I-IV улирал	Хариуцах нэгж
					Эхний хагас жил	Жилийн эцэс		
1	2	3	4	5	6	7	8	
<p><b>Стратеги төлөвлөгөөний зорилго:</b> Биет болон биет бус соёлынхоо уламжлалыг өвлүүлэн дэлгэрүүлж, түүх соёлоороо бахархан эх орноо хайрлах үзэл ухамсрыг төлөвшүүлэн түгээж, уран бүтээл туурвих таатай нөхцөлийг орчин бүрдүүлэн, хүний нөөцийн хангалт, ур чадварыг нэмэгдүүлж, соёл, урлагийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоог 2022 онд 313014 байсныг 2023 онд 322294-т хүргэнэ.</p>								
<p align="center"><b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b></p>								
Зорилт 1	Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг хөгжүүлнэ.	7,677,6 УТХО, ОНТ	Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	310719	150000	322294	I-IV улирал	Соёлын алба, Захиргаа, удирдлагын алба
1.1	Соёл урлагийн салбарын байгууллагуудыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах	22.1 ОНТ	Боловсон хүчнийг дэмжиж ажиллах арга зүйн чиглүүлэг хийсэн тоо	4	2	4	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
		2.7 УТ 2.8 ОНТ	Сургалтад хамруулсан ажилтны тоо /давхардсан тоогоор/	438	150	300	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс

1.2	“Уяхан замбуу тивийн наран” уртын дуучид, морин хуурчдын шавь бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах	15.0 ОНТ	Сургагч багш нартай хэлэлцүүлэг уулзалт хийсэн тоо	1	2	3	I-III улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Сургагч багшаар бэлтгэсэн хүний тоо	30	28	40		
			Эзэмших бүтээлийн тоо	5	5	5		
			Оролцогчийн хуваарь гаргаж, хүргэсэн эсэх (тийм-1, үгүй-0)	1	1	0		
			Шаардагдах зардлын төсвийн төслийн тооцоолол хийж, танилцуулсан тоо	1	1	0		
1.3	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн шүтэж байхыг уриалсан цахим арга хэмжээг зохион байгуулах	-	Уриалсан арга хэмжээний тоо	1	2	2	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
			Судалгаа авч, чиглэл өгсөн тоо	1	1	1		

1.4	Иргэдийн дунд соёлын боловсролын мэдлэг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	3	II улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
		9.8	Хамрагдсан иргэдийн тоо	1100	500	700		
1.5	Дуу хуурын өлгий нутгийн алдартан гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулахад арга зүйгээр хангаж, хамтран ажиллах	12.0 ОНТ	Арга зүйгээр хангаж, хамтарч ажилласан тоо	4	2	6	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
1.6	Хүүхэд гэр бүл рүү чиглэсэн иргэдийн хамтдаа амьдрах соёл, ахуйн соёл, монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлийг хүүхэд залуучуудад ойлгуулан таниулж сурталчлах	-	Хамрагдсан иргэдийн тоо	170	80	180	II-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
1.7	Монгол бичгийн өв соёлыг сурталчлан монгол бичгээр	-	Монгол бичгийн хаягжилтын судалгаа хийсэн тоо	0	2	2	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа,

	хаягжуулах арга хэмжээг уриалах		Шинээр хаягжилт хийсэн байгууллагын тоо	1	3	5		удирдлагын хэлтэс
1.8	Эерэг хандлагыг бий болгох соёл урлагийн цахим арга хэмжээг зохион байгуулж, цахим орчинд үе шаттайгаар идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	Арга хэмжээний тоо	3	2	1	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
Зорилт 2	Түүх соёлын биет болон биет бус өвийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	3.0 УТ	Үл хөдлөх дурсгалыг шинээр хаягжуулсан тоо	8	24	24	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
2.1	Соёлын хөдлөх дурсгалын улсын үзлэг зохион байгуулж, тайлагнах	3.0 УТ	Улсын үзлэгт хамруулсан сумын тоо	15	15	15	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Тайлагнасан эсэх (тийм-1, үгүй-0)	0	1	1		
2.2	"Ардын зан үйл-амьдрах ухаан" хөтөлбөрт сургалтыг хүүхдүүдийн дунд зохион байгуулах	-	Сургалтын тоо	5	2	5	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Хамруулсан иргэдийн тоо	95	50	100		

2.3	"Нүүдэлчин Монгол-2023" улсын наадамд оролцох	УТ, ОНТ	Өвлөн уламжлагчийг хамруулсан эсэх (тийм-1, үгүй-0)	1	0	1	II-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
2.4	Аймгийн "Адууны өв соёл" арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллах	ОНТ	Адууны өв соёлыг иргэдэд сурталчилсан эсэх (тийм-1, үгүй-0)	1	0	1	III улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
2.5	Угийн бичиг хөтлөлтийн талаарх байгууллагын ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	5.6 ОНТ	Угийн бичиг шинээр хөтөлсөн өрхийн тоо	1	2	3	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс
			Сургалт, мэдээлэлд хамрагдсан ажилтны тоо	15	15	15	I-IV улирал	
2.6	Аймгийн гар урчуудын бүтээлээр үзэсгэлэн-худалдаа зохион байгуулж, дэг сургууль, арга барилыг нь өвлүүлэх	-	Арга зүйн чиглүүлэг хийсэн тоо	2	1	3	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Шавь сургалтын тоо	5	3	5		

2.7	Аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах	-	Үл хөдлөх дурсгалыг эзэнжүүлсэн хувь	100	100	100	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
2.8	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үндэсний хяналтын тооллогод хамрагдах	0.2	Хяналтын тооллогод хамрагдаж, чиглэл авсан тоо	0	1	1	I улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
<b>ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>								
Зорилт 3	Монгол үндэсний өв соёлыг орон нутгийнхаа онцлогт нийцүүлэн туурвисан шинэ уран бүтээл 2021 онд 8 байсныг 2023 онд 9 болгож нэмэгдүүлнэ.	40,0	Хүүхдэд зориулсан шинэ болон шинэчилсэн уран бүтээл хийлгэх арга зүйгээр хангасан тоо	4	2	2	II-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
		ОНТ						
		12,0	Шинээр туурвисан болон шинэчилсэн уран бүтээлийн тоо	7	2	8	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
		ОНТ						



3.1	Аймгийн түүх, өв соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах Виртуал орчинг бүрдүүлэх	ОНТ	Өв соёлын үзүүлэг хийх арга зүйн чиглэл өгсөн тоо	1	1	2	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
3.2	Тусгай бүлгийн болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	УТ 10.0	Үйл ажиллагааг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн тоо	0	1	2	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
3.3	Хүний эрх, хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	3	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
3.4	Орон нутагт "Номын баяр-2023" арга хэмжээг зохион байгуулах	УТ	Үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх (тийм-1, үгүй-0)	1	1	1	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
3.5	Соёлын байгууллагуудад зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	1.3 ОНТ	Зөвлөн тусалсан тоо	6	1	5	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
3.6	Соёл урлагийн салбарын статистик мэдээг гаргаж, улсын нэгтгэлд оруулан, холбогдох байгууллага,	-	Мэдээ гаргалтын хувь	100	100	100	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс

	мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах							
3.7	Соёлын байгууллагуудын удирдлага, маркетинг бичиг хэргийн ажилтнуудыг "Байгууллагын төлөвлөгөө боловсруулах нь" арга зүйн сургалтад хамруулах	-	Сургалтын тоо	1	1	1	I улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Хамрагдсан ажилтны эзлэх хувь	50	55	55		
3.8	Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийг алслагдсан сумын иргэдэд хүргэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх	-	Орон нутгийн хүн амын эзлэх хувь	15	10	15	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс
3.9	Салбарын байгууллагын удирдлага, бичиг хэргийн ажилтнуудыг "Архив, бичиг хэрэг стандарт"-ын сургалтад хамруулах	-	Сургалтын тоо	0	1	1	II улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Хамрагдсан ажилтны эзлэх хувь	0	60	60		
3.10			Зохион байгуулсан ажлын тоо	1	1	2	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс

	"Бүх нийтээр хос бичигтэн болох" нөлөөллийн ажлыг зохион байгуулах	-	Хамрагдсан иргэдийн тоо	150	400	800		Захиргаа, удирдлагын хэлтэс
3.11	Соёлын салбарын үйл ажиллагаанд Цахим соёл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ERP, E-Mongolia систем, тоон гарын үсэг нэвтрүүлэх, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх	-	e-mongolia ашигладаг албан хаагчийн хувь	66.6	66.5	66.5	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Үйл ажиллагааны мэдээллийг цахимд байршуулсан тоо	18	10	20	I-IV улирал	
3.12	Хулд сумын соёлын төвийг жишиг болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	Арга зүйн дэмжлэг үзүүлсэн тоо	3	2	3	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
Зорилт 4	Соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулна.	УТ, ОНТ	Ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан байгууллагын тоо	2	1	3	IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
4.1	Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумын соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого	1210.0 УТХО	Баригдсан соёлын төвийн тоо	2	2	2	II-IV улирал	Захиргаа, удирдлагын хэлтэс

	баримталж, барилга байгууламжуудыг шинэчлэх							
4.2	Соёл, урлагийн газрын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ажиллах байр орчин нөхцөлийг бүрдүүлэх	ОНТ	Зохион байгуулсан ажлын тоо	2	1	1	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
4.3	“Ном хандивлах сайхан” үйл ажиллагааг зохион байгуулах	Хандив	Хандивласан номын тоо	0	10	15	II улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
			Хамтарч ажилласан байгууллагын тоо	0	3	5		
Зорилт 5	Соёл, урлагийн салбарын хөгжлийг тодорхойлох бодлогын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулан хэрэгжүүлнэ.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	5	2	5	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
5.1	Байгууллагын ёс зүйн дүрэм боловсруулах	-	Боловсруулсан эсэх (тийм-1, үгүй-0)	0	1	1	I-II улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс

5.2	Соёлын боловсрол олгох хөтөлбөр боловсруулах	-	Дүрмийн төсөлд санал боловсруулан хүргэсэн тоо	0	1	1	I-IV улирал	Соёл, урлагийн хэлтэс
5.3	Соёлын төв, соёлын ордны дүрмийг шинэчлэн батлах ажлыг зохион байгуулах	-	Дүрмийн төсөлд санал боловсруулан хүргэсэн тоо	0	1	1	I-II улирал	Соёл, урлагийн хэлтэс
5.4	Музейн үзэл баримтлал, үзүүлэг дэглэлтийн төлөвлөгөө боловсруулах	-	Төлөвлөгөө боловсруулах арга зүйн дэмжлэг үзүүлсэн тоо	1	1	2	I-IV улирал	Соёл урлагийн хэлтэс Захиргаа, удирдлагын хэлтэс
1	Зорилт 1	Арга хэмжээ						8
2	Зорилт 2	Арга хэмжээ						8
3	Зорилт 3	Арга хэмжээ						12
4	Зорилт 4	Арга хэмжээ						3
5	Зорилт 5	Арга хэмжээ						4
Зорилтын тоо-5, Арга хэмжээний тоо-35								

ТӨЛӨВЛӨГӨӨ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:



С.ОТГОНБЯМБА